ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** САГ-2026/103/НА-СТА-ТШЗ


| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | **Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг**<br>Утас: 51-261663 Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn<br>**Аудитын менежер: Э.Энхбаатар**<br>Утас: 51-260512 Цахим хаяг: Enkhbaatare@audit.gov.mn<br>**Ахлах аудитор: П.Батцэцэг**<br>Утас: 51-261628 Цахим хаяг: Battsetsegp@audit.gov.mn<br>**Аудитор: Ч.Мөнхбулган**<br>Утас: 51-261628 Цахим хаяг: Munkhbulganch@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .... 4**
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .... 7**
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .... 8
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .... 8
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .... 10
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .... 12
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .... 13
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .... 15**
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .... 16
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .... 16
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .... 16
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .... 17
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .... 18
3.5.1 Төсвийн төлөвлөлт .... 18
3.5.2 Төсвийн гүйцэтгэл .... 18
3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл .... 20
**4. АУДИТЫН ТАЙЛАН .... 20**
4.1 Ерөнхий зүйл .... 21
4.2 Материаллаг байдал .... 21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .... 21
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .... 21
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .... 22
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .... 22
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .... 23
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .... 23
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .... 23
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .... 23**
5.1 Төлбөрийн акт .... 24
5.2 Албан шаардлага .... 24
5.3 Зөвлөмж .... 29
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .... 30**

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ДМАЭМБ | Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага |
| МУЕС | Монгол Улсын Ерөнхий Сайд |
| МЭЕГ | Мал эмнэлгийн ерөнхий газар |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| СҮДТ | Санхүүгийн үр дүнгийн тайлан |
| ТБОНӨХБАҮХАТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТӨХХК | Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ХХААХҮЯ | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/287

танай ____________-ны №____________-т

МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАТСҮХ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал эмнэлгийн ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлаас дотоод томилолтын зардалд 19,174.3 мянган төгрөг, гадаад томилолтын зардалд 206,428.7 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 41,427.4 мянган төгрөг, нийт 267,030.3 мянган төгрөгийг зардлын эдийн засгийн ангилал зөрүүлэн зарцуулж, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй;
- Оны эцэст шаардлагагүй вакцин нөөцөлснөөс үүдэн 2017-2025 онд хугацаа нь дууссан цаашид ашиглах боломжгүй нийт 349,313.9 мянган төгрөгийн 6 нэр төрлийн вакцин, 2 нэр төрлийн шингэлэгчийн үлдэгдэлтэй байна;
- Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй нийт 229,504.8 мянган төгрөгийн ажил гүйцэтгэх, вакцин худалдан авах гэрээг байгуулсан.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Мал эмнэлгийн салбарын үндсэн үйл ажиллагаатай холбоотой жил бүр давтагдах шинж чанартай дархлаажуулалтыг зохион байгуулах үйлчилгээний хөлсийг харьяа 22 байгууллагын нэмэлт санхүүжилтийн данс руу шилжүүлж төсвийн үндсэн зарчмыг алдагдуулснаас тайлант онд 11,540,238.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, татаас санхүүжилтийн авлагаар тайлагнасан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Мал эмнэлгийн ерөнхий газар нь Дэлхийн Мал, амьтны эрүүл мэндийн байгууллага, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагатай хамтран 2025 оны 4 дүгээр сарын 01-ээс 03-ны өдрүүдэд нийт 7 орны 40 гаруй эрдэмтэн, судлаачидтай “Зүүн өмнөд Азийн бүсийн бог малын мялзан өвчний тархвар зүй” сэдэвт олон улсын бага хурлыг Монгол Улсад зохион байгуулж, олон улсын худалдааны хоригтой мал, амьтны гоц халдварт бог малын мялзан өвчинтэй тэмцэж байгаа арга хэмжээний үр дүнг хэлэлцүүлсэн нь Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын стандарт, заавар, зөвлөмжийг хэрэгжүүлж байгаагаа хөрш зэргэлдээ орнуудад дэлгэрэнгүй танилцуулах, экспортыг нэмэгдүүлэх боломж юм.

**Бусад асуудал**

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитыг хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ.

Тайлант онд мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 46.1 сая толгой мал хамруулахаар төлөвлөснөөс гүйцэтгэл 97.3 хувьтай буюу 44.9 сая толгой мал, амьтан хамруулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамаараагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

Z:\Yawsan_Bichig\2026\0225 SAG-8.Docx

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **30,777,430,728.41** | **22,809,086,681.98** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **11,515,907,196.02** | **-** |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 11,515,907,196.02 | - |
| **33** | **АВЛАГА** | **1,860,110,003.62** | **11,585,956,130.40** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 5,898,363.66 | 882,689.17 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | 11,540,238,597.02 |
| 33402 | Татвар, НДШ-ийн авлага | - | 305,271.21 |
| **335** | **Бусад авлага** | **1,854,211,639.96** | **44,529,573.00** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 1,788,527,207.90 | 10,000.00 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 65,684,432.06 | 44,519,573.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | **205,821,620.00** | **15,120,000.00** |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 205,821,620.00 | 15,120,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **17,195,591,908.77** | **11,208,010,551.58** |
| 35100 | Түүхий эд материал | 16,048,706,426.68 | 9,755,696,934.06 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | - | 876,720.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **1,146,885,482.09** | **1,451,436,897.52** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 54,541,955.71 | 30,614,957.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 43,869,843.00 | 210,759,022.10 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | - | 593,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 8,387,476.02 | 1,662,318.71 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,040,086,207.36 | 1,207,807,599.71 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,369,217,487.84** | **1,716,282,296.16** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,369,217,487.84** | **1,716,282,296.16** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **621,887,664.62** | **941,100,429.66** |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 535,536,000.00 | 488,905,455.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (392,314,000.00) | (279,536,666.63) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 859,648,505.85 | 846,404,500.85 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (468,471,954.12) | (455,513,410.40) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 138,830,200.00 | 408,086,800.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (51,341,087.11) | (67,246,249.16) |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **747,329,823.22** | **775,181,866.50** |
| 39301 | Программ хангамж | 549,598,102.00 | 667,487,749.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (146,918,278.78) | (236,955,882.50) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 344,650,000.00 | 344,650,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **32,146,648,216.25** | **24,525,368,978.14** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **11,515,907,196.02** | **21,581,955,282.99** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **11,515,907,196.02** | **21,581,955,282.99** |
| **41300** | **Өглөг** | **11,515,907,196.02** | **21,581,955,282.99** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 105,797.95 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 11,335,200.02 |
| **4136** | **Бусад өглөг** | **11,515,907,196.02** | **21,570,514,285.02** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 11,515,907,196.02 | 21,570,089,285.02 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 425,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **20,630,741,020.23** | **2,943,413,695.15** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **20,630,741,020.23** | **2,943,413,695.15** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 870,951,254.96 | 870,951,254.96 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **19,759,789,765.27** | **2,072,462,440.19** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 9,555,457,057.94 | 19,759,789,765.27 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 10,204,332,707.33 | (17,687,327,325.08) |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **32,146,648,216.25** | **24,525,368,978.14** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **66,091,005,290.45** | **36,359,066,468.47** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,446,841,120.45** | **36,359,066,468.47** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **2,446,841,120.45** | **1,241,333,999.44** |
| **120004** | **Төсөвт байгууллагын өөрийн орлого** | **55,047,164.80** | **139,990,097.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 55,047,164.80 | 139,990,097.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 9,498,866.59 | 644,996,905.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 2,382,295,089.06 | 456,346,997.44 |
| **122** | **Тусламжийн орлого** | **-** | **35,117,732,469.03** |
| **1221** | **Хандив тусламж/дотоод/** | **-** | **35,103,387,169.03** |
| 12211 | Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | - | 35,103,387,169.03 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | - | 35,103,387,169.03 |
| **12213** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **-** | **14,345,300.00** |
| 122135 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 14,345,300.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **63,644,164,170.00** | **-** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **63,599,183,600.00** | **-** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 63,599,183,600.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **44,980,570.00** | **-** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 17,304,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 27,676,570.00 | - |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **55,789,492,332.94** | **54,008,020,434.49** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **55,789,492,332.94** | **54,008,020,434.49** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **54,300,716,393.47** | **53,926,827,450.66** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,472,884,240.83** | **1,719,669,951.95** |
| 210101 | Үндсэн цалин | 816,500,219.33 | 915,858,007.00 |
| 210102 | Нэмэгдэл | 308,495,558.67 | 386,371,651.63 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 229,131,000.00 | 305,944,595.13 |
| 210104 | Урамшуулал | 118,757,462.83 | 111,495,698.19 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **193,252,375.49** | **218,802,665.76** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 132,363,975.49 | 152,590,860.53 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 15,592,100.00 | 18,853,587.11 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,796,000.00 | 9,877,958.80 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 7,796,100.00 | 9,722,436.28 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 29,704,200.00 | 27,757,823.04 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **21,080,700.00** | **39,733,600.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,125,400.00 | 14,651,900.00 |
| 210302 | Түлш, халаалт | 1,820,000.00 | 5,274,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,354,800.00 | 9,906,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 13,780,500.00 | 9,901,500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **125,941,840.24** | **4,629,002,227.08** |
| 210401 | Бичиг хэрэг | 41,403,970.00 | 30,570,477.91 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 31,287,478.02 | 17,206,921.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 8,447,296.82 | 9,990,188.42 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 28,871,370.00 | 26,529,374.55 |

| | | | |
|---|---|---|---|
| 210408 | Бараа материал акталсны зардал | 15,931,725.40 | - |
| 210409 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/ | - | 4,544,705,265.20 |
| **2105** | **Нормативт зардал** | **21,454,775,895.97** | **20,596,155,984.85** |
| 210501 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 21,454,775,895.97 | 20,596,155,984.85 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **493,056,300.00** | **717,000,878.14** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 442,053,200.00 | 665,682,843.60 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 7,854,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 51,003,100.00 | 43,464,034.54 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **472,481,287.00** | **199,732,272.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 472,481,287.00 | 199,732,272.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **29,713,177,090.69** | **25,443,919,488.20** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 29,680,661,854.69 | 25,402,506,180.20 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 144,948.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 557,766.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,107,470.00 | 1,919,434.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 70,000.00 | 87,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 30,780,000.00 | 39,261,926.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **354,066,663.25** | **362,810,382.68** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,918,017.00 | 308,520.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 19,474,532.40 | 3,520,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 329,674,113.85 | 358,981,862.68 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,488,775,939.47** | **81,192,983.83** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **-** | **31,850,713.83** |
| **21311** | **Засгийн газрын дотоод шилжүүлэг** | **-** | **31,850,713.83** |
| **213112** | **Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал** | **-** | **31,850,713.83** |
| 2131121 | Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 31,850,713.83 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **193,078,663.00** | **47,539,970.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 9,582,000.00 | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 59,443,729.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 124,052,934.00 | 47,539,970.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **1,295,697,276.47** | **1,802,300.00** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,295,376,640.47 | 1,802,300.00 |
| 213306 | Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг | 320,636.00 | - |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **10,301,512,957.51** | **(17,648,953,966.02)** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **97,180,250.18** | **38,373,359.06** |
| 210904 | Найдваргүй авлагын алдагдал | - | 21,164,859.06 |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал- Үндсэн хөрөнгө | 97,180,250.18 | 12,000,000.00 |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал- Бараа материал | - | 5,208,500.0 |
| **VII** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН** | **(97,180,250.18)** | **(38,373,359.06)** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **10,204,332,707.33** | **(17,687,327,325.08)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **75,215,118,530.82** | **46,701,474,766.05** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **11,570,954,360.82** | **46,701,474,766.05** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **11,570,954,360.82** | **11,583,742,297.02** |
| **120004** | **Төсөвт байгууллагын өөрийн орлого** | **11,570,954,360.82** | **143,493,797.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 55,047,164.80 | 139,990,097.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 11,515,907,196.02 | 3,503,700.00 |
| 120009 | Бусад орлого | - | 11,440,248,500.02 |
| **122** | **Тусламжийн орлого** | **-** | **35,117,732,469.03** |
| **1221** | **Хандив тусламж /дотоод/** | **-** | **35,117,732,469.03** |
| **12211** | **Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого** | **-** | **35,103,387,169.03** |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | - | 35,103,387,169.03 |
| **12213** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **-** | **14,345,300.00** |
| 122135 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 14,345,300.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **63,644,164,170.00** | **-** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **63,599,183,600.00** | **-** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 63,599,183,600.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **44,980,570.00** | **-** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 17,304,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 27,676,570.00 | - |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **63,575,224,892.80** | **58,144,332,196.07** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **63,575,224,892.80** | **58,144,332,196.07** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **62,086,448,953.33** | **46,524,412,615.22** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,511,014,502.84** | **1,708,935,105.25** |
| 210101 | Үндсэн цалин | 854,630,481.34 | 905,123,160.30 |
| 210102 | Нэмэгдэл | 308,495,558.67 | 386,371,651.63 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 229,131,000.00 | 305,944,595.13 |
| 210104 | Урамшуулал | 118,757,462.83 | 111,495,698.19 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **192,041,556.14** | **224,721,311.23** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 131,153,156.14 | 158,509,506.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 15,592,100.00 | 18,853,587.11 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,796,000.00 | 9,877,958.80 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 7,796,100.00 | 9,722,436.28 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 29,704,200.00 | 27,757,823.04 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **21,080,700.00** | **54,853,600.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,125,400.00 | 14,651,900.00 |
| 210302 | Түлш, халаалт | 1,820,000.00 | 5,274,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,354,800.00 | 9,906,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 13,780,500.00 | 25,021,500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **71,027,196.82** | **48,673,238.42** |
| 210401 | Бичиг хэрэг | 20,659,100.00 | 13,027,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,398,400.00 | 10,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 8,447,296.82 | 9,990,188.42 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 22,522,400.00 | 15,656,050.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **25,125,376,721.73** | **5,050,910,277.39** |

| | | | |
|---|---|---|---|
| 210501 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 25,125,376,721.73 | 5,050,910,277.39 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **497,504,191.40** | **721,286,568.14** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 444,608,491.40 | 671,250,133.60 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,556,400.00 | 7,854,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 50,339,300.00 | 42,182,434.54 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **472,481,287.00** | **199,732,272.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 472,481,287.00 | 199,732,272.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **34,174,998,265.00** | **38,511,780,242.79** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 34,135,765,109.00 | 38,470,511,882.79 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 7,275,686.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,107,470.00 | 1,919,434.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 70,000.00 | 87,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 30,780,000.00 | 39,261,926.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **20,924,532.40** | **3,520,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,450,000.00 | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 19,474,532.40 | 3,520,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,488,775,939.47** | **11,619,919,580.85** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **-** | **11,572,089,310.85** |
| **21311** | **Засгийн газрын дотоод шилжүүлэг** | **-** | **11,572,089,310.85** |
| **213112** | **Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал** | **-** | **11,572,089,310.85** |
| 2131121 | Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 31,850,713.83 |
| 2131125 | Төсвийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 11,540,238,597.02 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **193,078,663.00** | **46,027,970.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 9,582,000.00 | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 59,443,729.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 124,052,934.00 | 46,027,970.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **320,636.00** | **1,802,300.00** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 1,802,300.00 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 320,636.00 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **1,295,376,640.47** | **-** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,295,376,640.47 | - |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **11,639,893,638.02** | **(11,442,857,430.02)** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **123,986,442.00** | **73,049,766.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **123,986,442.00** | **73,049,766.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **123,986,442.00** | **73,049,766.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 123,986,442.00 | 73,049,766.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(123,986,442.00)** | **(73,049,766.00)** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **11,515,907,196.02** | **(11,515,907,196.02)** |
| IX | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 11,515,907,196.02 |
| X | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 11,515,907,196.02 | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **870,951,254.96** | **-** | **9,555,457,057.94** | **10,426,408,312.90** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | **-** | **-** | **-** | **-** |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 870,951,254.96 | **-** | **9,555,457,057.94** | **10,426,408,312.90** |
| Тайлант үеийн үр дүн | **-** | **-** | 10,204,332,707.33 | 10,204,332,707.33 |
| **2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **870,951,254.96** | **-** | **19,759,789,765.27** | **20,630,741,020.23** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 870,951,254.96 | **-** | 19,759,789,765.27 | 20,630,741,020.23 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (17,687,327,325.08) | (17,687,327,325.08) |
| **2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **870,951,254.96** | **-** | **2,072,462,440.19** | **2,943,413,695.15** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *Ітөгрөгөөр/*

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **57,261,883,300.00** | **35,215,030,252.20** | **22,046,853,047.80** | **61.5** |
| **Татварын бус орлого** | **57,261,883,300.00** | **35,215,030,252.20** | **22,046,853,047.80** | **61.5** |
| **Нийтлэг татварын бус орлого** | **40,000,000.00** | **143,493,797.00** | **(103,493,797.00)** | **358.7** |
| Төсөвт байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 40,000,000.00 | 139,990,097.00 | (99,990,097.00) | 350.0 |
| Төсөвт байгууллагын өөрийн орлого /туслах/ | - | 3,503,700.00 | (3,503,700.00) | - |
| **Тусламжийн орлого** | **57,221,883,300.00** | **35,071,536,455.20** | **22,150,346,844.80** | **61.3** |
| Төсвөөс санхүүжих | 57,221,883,300.00 | 35,071,536,455.20 | 22,150,346,844.80 | 61.3 |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **57,261,883,300.00** | **35,115,040,155.20** | **22,146,843,144.80** | **61.3** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **57,261,883,300.00** | **35,115,040,155.20** | **22,146,843,144.80** | **61.3** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **57,222,433,700.00** | **35,081,555,185.20** | **22,140,878,514.80** | **61.3** |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,739,315,800.00** | **1,708,935,105.25** | **30,380,694.75** | **98.3** |
| Үндсэн цалин | 994,659,500.00 | 905,123,160.30 | 89,536,339.70 | 91.0 |
| Нэмэгдэл | 380,449,700.00 | 386,371,651.63 | (5,921,951.63) | 101.6 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 235,663,600.00 | 305,944,595.13 | (70,280,995.13) | 129.8 |
| Урамшуулал | 128,543,000.00 | 111,495,698.19 | 17,047,301.81 | 86.7 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **252,690,000.00** | **224,721,311.23** | **27,968,688.77** | **88.9** |
| Тэтгэврийн даатгал | 161,748,900.00 | 158,509,506.00 | 3,239,394.00 | 98.0 |
| Тэтгэмжийн даатгал | 26,335,200.00 | 18,853,587.11 | 7,481,612.89 | 71.6 |
| ҮОМШӨ-ний даатгал | 14,395,200.00 | 9,877,958.80 | 4,517,241.20 | 68.6 |
| Ажилгүйдлийн даатгал | 11,667,600.00 | 9,722,436.28 | 1,945,163.72 | 83.3 |
| Эрүүл мэндийн даатгал | 38,543,100.00 | 27,757,823.04 | 10,785,276.96 | 72.0 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **58,641,800.00** | **54,853,600.00** | **3,788,200.00** | **93.5** |
| Гэрэл, цахилгаан | 15,903,500.00 | 14,651,900.00 | 1,251,600.00 | 92.1 |
| Түлш, халаалт | 6,385,100.00 | 5,274,200.00 | 1,110,900.00 | 82.6 |
| Цэвэр, бохир ус | 11,317,700.00 | 9,906,000.00 | 1,411,700.00 | 87.5 |
| Байрны түрээс | 25,035,500.00 | 25,021,500.00 | 14,000.00 | 99.9 |
| **Хангамж, бараа материалын зардал** | **71,810,200.00** | **48,673,238.42** | **23,136,961.58** | **67.8** |
| Бичиг хэрэг | 24,550,000.00 | 13,027,000.00 | 11,523,000.00 | 53.1 |
| Тээвэр, шатахуун | 12,500,000.00 | 10,000,000.00 | 2,500,000.00 | 80.0 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 13,690,000.00 | 9,990,188.42 | 3,699,811.58 | 73.0 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 21,070,200.00 | 15,656,050.00 | 5,414,150.00 | 74.3 |
| **Нормативт зардал** | **18,538,467,500.00** | **5,050,910,277.39** | **13,487,557,222.61** | **27.2** |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 18,538,467,500.00 | 5,050,910.277.39 | 13,487,557,222.61 | 27.2 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | **792,967,200.00** | **752,908,963.14** | **40,058,236.86** | **94.9** |
| Багаж, техник, хэрэгсэл | 727,657,700.00 | 702,872,528.60 | 24,785,171.40 | 96.6 |
| Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 7,854,100.00 | 7,854,000.00 | 100.0 | 100.0 |
| Урсгал засвар | 57,455,400.00 | 42,182,434.54 | 15,272,965.46 | 73.4 |
| **Томилолт, зочны зардал** | **216,000,000.00** | **199,732,272.00** | **16,267,728.00** | **92.5** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Дотоод албан томилолт | 216,000,000.00 | 199,732,272.00 | 16,267,728.00 | 92.5 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **35,536,171,200.00** | **27,037,300,417.77** | **8,498,870,782.23** | **76.1** |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 35,480,995,300.00 | 26,996,032,057.77 | 8,484,963,242.23 | 76.1 |
| Даатгалын үйлчилгээ | 8,190,000.00 | - | 8,190,000.00 | - |
| Тээврийн хэрэгслийн татвар | 3,125,000.00 | 1,919,434.00 | 1,205,566.00 | 61.4 |
| Тээврийн хэрэгслийн оношилгоо | 1,099,000.00 | 87,000.00 | 1,012,000.00 | 7.9 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 42,761,900.00 | 39,261,926.00 | 3,499,974.00 | 91.8 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **16,370,000.00** | **3,520,000.00** | **12,850,000.00** | **21.5** |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 4,500,000.00 | - | 4,500,000.00 | - |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,870,000.00 | 3,520,000.00 | 8,350,000.00 | 29.7 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **39,449,600.00** | **33,484,970.00** | **5,964,630.00** | **84.9** |
| **Бусад урсгал шилжүүлэг** | **39,449,600.00** | **33,484,970.00** | **5,964,630.00** | **84.9** |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 39,449,600.00 | 33,484,970.00 | 5,964,630.00 | 84.9 |
| **ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ** | **-** | **99,990,097.00** | **(99,990,097.00)** | **-** |
| **АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **-** | **(99,990,097.00)** | **99,990,097.00** | **-** |
| **Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт** | **-** | **(99,990,097.00)** | **99,990,097.00** | **-** |
| **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **77** | **77** | **-** | **100.0** |
| **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** | **-** | **100.0** |
| **Төсвийн байгууллага** | **1** | **1** | **-** | **100.0** |
| **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **39** | **39** | **-** | **100.0** |
| Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| Гүйцэтгэх ажилтан | 36 | 36 | - | 100.0 |
| Үйлчлэх ажилтан | 2 | 2 | - | 100.0 |
| **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **39** | **39** | **-** | **100.0** |
| Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 36 | 36 | - | 100.0 |
| Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 3 | 3 | - | 100.0 |
| **НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ** | **-** | **-** | **-** | **-** |
| Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч | - | - | **-** | **-** |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мал эмнэлгийн ерөнхий газар нь эрхэм зорилгоо “Мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл, аюулгүй байдлыг баталгаажуулах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах замаар мал эмнэлгийн салбарыг оновчтой нэгдсэн бодлогоор хангаж, худалдааны чөлөөт байдлыг дэмжихэд оршино” гэж тодорхойлсон байна.

Тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааны эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан стратегийн зорилтыг хэрэгжүүлж байна.Үүнд:

- Мал амьтны өвчний тохиолдол, тархалт, оношилгоо, тандалтын мэдээллийг бүртгэх, боловсруулах, тархвар зүйн судалгаа, тооцоо, дүн шинжилгээ хийх, программ хангамж, системийн хөгжүүлэлтийн асуудлыг хариуцан, урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг төлөвлөх, мэдээ мэдээллээр хангах;
- Мал амьтны гоц халдварт, халдварт, зооноз, шимэгчлэх, халдваргүй өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжилт, тавлаг байдлыг хангах, эм био бэлдмэлийн үйлдвэрлэл, хэрэглээний стандартыг хангуулах;
- Мал, амьтны өвчингүй тайван байдал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, эм, эмнэлгийн хэрэгслийн аюулгүй байдал, мал эмнэлгийн үйлчилгээг баталгаажуулах, хянах, үнэлэх, хүний нөөцийг чадавхжуулах, итгэмжлэх, экспорт, импортын дэмжлэг үзүүлэх, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх;
- Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн туслалцаа үзүүлэх, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, санхүүгийн аудит хийх, олон нийтийн мэдээ, мэдээллээр хангах, олон талт гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх;

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар нь Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Төрийн албаны тухай хуулиуд болон түүнийг дагалдан гарсан заавар, журам, “Төрөөс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын дагуу мал, амьтны болон нийгмийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, мал эмнэлгийн лабораторийн хүчин чадлыг сайжруулах, малын өвчин эмгэгтэй тэмцэх, хүн ам, эрүүл мэндийг хамгаалах, хүнсний аюулгүй байдал, худалдааны чөлөөт байдлыг баталгаажуулах зорилтыг хэрэгжүүлэн ажилладаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаанд мөрддөг Амьтны тухай хууль, Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон, мөн “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар шинэчлэн баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 04-ний А/385 дугаар тушаалаар баталсан “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөн ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,621,279.2 мянган төгрөгөөр буюу 23.7 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 11,515,907.2 | - | (11,515,907.2) |
| Авлага | 1,860,110.0 | 11,585,956.1 | 9,725,846.1 |
| Урьдчилгаа | 205,821.6 | 15,120.0 | (190,701.6) |
| Бараа материал | 17,195,591.9 | 11,208,010.6 | (5,987,581.3) |
| Үндсэн хөрөнгө | 1,369,217.5 | 1,716,282.3 | 347,064.8 |
| **Нийт хөрөнгө** | **32,146,648.2** | **24,525,369.0** | **(7,621,279.2)** |
| Өр төлбөр | 11,515,907.2 | 21,581,955.3 | 10,066,048.1 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 20,630,741.0 | 2,943,413.7 | (17,687,327.3) |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **32,146,648.2** | **24,525,369.0** | **(7,621,279.2)** |

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах дансдууд байна. Тухайлбал,

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 2024 онд ОХУ-аас худалдан авсан шүлхийн вакцины үлдэгдэл 11,515,907.2 мянган төгрөгөөр буурсан;
- Авлага дансны үлдэгдэл 11,585,956.1 мянган төгрөгт хүрсэн нь 2025 оны вакцинжуулалтын тарилгын үйлчилгээний хөлсний 11,540,238.6 мянган төгрөгийн үлдэгдэл санхүүжилтийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэнтэй холбоотой;
- Урьдчилгаа дансны үлдэгдэл 15,120.0 мянган төгрөгт хүрч, 190,701.6 мянган төгрөгөөр буурсан нь урьдчилж гарсан түрээсийн зардлыг зардлаар тайлагнасан;

- Бараа материал дансны үлдэгдэл 11,208,010.6 мянган төгрөгт хүрч, 5,987,581.3 мянган төгрөгөөр буурсан нь Эм боох материал, бусад хангамжийн материал данснаас вакцин болон бусад материалыг орон нутагт шилжүүлсэнтэй холбоотой;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл ХХААХҮЯ-ны хөрөнгө оруулалтаар Машин тоног төхөөрөмж, Тавилга эд хогшил, Программ хангамж балансаас балансад шилжүүлэн авсан 452,116.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант оны элэгдлийн зардал 378,775.0 мянган төгрөгөөр буурсан;
- Өр төлбөр дансны үлдэгдэл 21,581,955.3 мянган төгрөгт хүрч, 10,066,048.1 мянган төгрөгөөр өссөн нь мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд вакцинжуулалтын үйлчилгээний хөлс, шүлхий, бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын вакцин, гэрээгээр гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, оношлуур хэрэглэгдэхүүний худалдан авалтыг өглөгөөр тайлагнасан;
- Засгийн газрын хувь оролцоо данс тайлант үеийн үр дүн 17,687,327.3 мянган төгрөгөөр буурсан.

Мал эмнэлгийн ерөнхий газрын Биет бус хөрөнгийн дансанд 988,300.1 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй Малын эрүүл мэндийн мэдээллийн систем, Мал эмнэлгийн гэрчилгээний систем, Мал эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн үлдэгдлийн бүртгэлийн программ, Малын эмийн бүртгэл мэдээллийн сан, И-оффис бүртгэлийн программ болон Санхүүгийн программууд бүртгэлтэй байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 85,364,245.5 мянган төгрөг бүрдүүлэхээр, нийт зарлагыг 85,364,245.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас бараа үйлчилгээний зардлыг 21,641,073.3 мянган төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 2,550.4 мянган төгрөг, нийт 21,643,623.7 мянган төгрөгөөр урсгал зардлыг бууруулж, нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 63,680,621.8 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 40,000.0 мянган төгрөгөөр баталсан нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

Тайлант онд батлагдсан төсвийн бараа үйлчилгээний зардлыг 6,470,738.5 мянган төгрөгөөр бууруулж, урсгал шилжүүлгийн зардлыг 12,000.0 мянган төгрөг нэмэгдүүлж, нийт 6,458,738.5 мянган төгрөгөөр урсгал зардлыг бууруулж, 57,261,883.3 мянган төгрөгөөр төсвийг тодотгосон байна.

Төсөв захирагчийн тайлант онд хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 57,221,883.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 40,000.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 46,543,635.7 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогоос 139,990.1 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 3,503.7 мянган төгрөг, нийт 46,687,129.5 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг

бүрдүүлж, бараа, ажил үйлчилгээний зардалд 35,081,555.2 мянган төгрөг, урсгал шилжүүлгийн зардалд 33,485.0 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 11,572,089.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 35,115,040.2 мянган төгрөг буюу 61.3 хувьтай байгаа нь Мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөрийн зардлыг 21,974,884.1 мянган төгрөг, Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого удирдлагын зардлыг 173,164.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөгөөр/*

| Д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **70801** | **Мал аж ахуйг хөгжүүлэх** | **54,832,536.5** | **32,857,652.4** | **21,974,884.1** | **59.9%** |
| 82504 | Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх | 7,021,350.3 | 4,059,626.0 | 2,961,724.3 | 57.8% |
| 82506 | Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх | 37,985,026.1 | 26,417,124.9 | 11,567,901.2 | 69.5% |
| 82507 | Малын архаг халдварт өвчнөөс эрүүлжүүлэх | 6,011,037.2 | 179,892.0 | 5,831,145.2 | 3.0% |
| 82508 | Малын өвчний лабораторийн оношилгоо, шинжилгээ | 1,895,500.0 | 902,206.0 | 993,294.0 | 47.6% |
| 82510 | Мал эмнэлгийн ариутгал, халдваргүйжүүлэлт | - | - | - | - |
| 82548 | Мал, амьтан эрүүлжүүлэх | 1,919,622.9 | 1,298,803.5 | 620,819.4 | 67.7% |
| **70805** | **Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого удирдлага** | **2,430,552.4** | **2,257,387.8** | **173,164.6** | **92.9%** |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 2,290,570.2 | 2,147,507.8 | 143,062.4 | 93.8% |
| 80103 | Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ | 82,532.6 | 76,395.0 | 6,137.6 | 92.6% |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг | 39,449.6 | 33,485.0 | 5,964.6 | 84.9% |
| 81569 | Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх | 18,000.0 | - | 18,000.0 | - |

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 52 дугаар “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолоор Мал эмнэлгийн ерөнхий газрын орон тооны дээд хязгаарыг 39 орон тоотой байхаар баталсан. Батлагдсан тогтоолын хүрээнд тус газар нь сул орон тоонд нөхөн томилгоо хийгээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам”-ын 8.4 дэх хэсгийн заалтуудыг тус тус үндэслэн Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны А/371 дүгээр тушаалаар хоолны хөнгөлөлтийг 32,000 төгрөг, унааны хөнгөлөлтийг 3,000 төгрөг байхаар баталсан байна. Тайлант онд гүйцэтгэлээр хоол, унааны хөнгөлөлтөд 305,944.6 мянган төгрөгийг зарцуулсан.

Мал эмнэлгийн ерөнхий газар нь тайлант онд Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас гадаад томилолтын зардалд 206,428.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тайлант онд Гамшгаас хамгаалах команд штабын сургууль болон Мал эмнэлгийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн зохион байгуулахад нийт 161,370.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тайлант онд Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагаа болон малын эмийн зохистой хэрэглээ, хүртээмж, хангамжийг олон нийтэд мэдээлэн сурталчлан таниулах арга хэмжээг 11 хэвлэл мэдээллийн байгууллагатай 174,900.0 мянган төгрөгийн гэрээг байгуулж, гүйцэтгэлээр 148,920.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Мал эмнэлгийн ерөнхий газар нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны А/17, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны А/50 дугаар тушаалуудаар нийт 17,812,216.4 мянган төгрөгийн 55 бараа, ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж баталсан байна.

Гүйцэтгэлээр 16,898,115.6 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 16 бараа, ажил, үйлчилгээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 12,137,064.6 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 10 бараа, ажил, үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 4,761,050.9 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 6 бараа, ажил, үйлчилгээг нэг эх үүсвэрээс худалдан авах аргаар гэрээ байгуулж худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мал эмнэлгийн ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, дотоод хяналтыг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор П.Батцэцэг, аудитор Ч.Мөнхбулган нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/113 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 55,886,672.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцож 588,866.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд албан хэрэг хөтлөлтийг цахимжуулах, албан томилолтоор онгоцоор явахад энгийн ангиллаар зорчих, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл бэлдэхгүй байх, ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авалтыг гүйцэтгэх зэргээр хуульд заасан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 2,021,430.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 2 зөвлөмж өглөө.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

*Илрүүлэлт:* Өмнөх аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг хугацаа хоцроосон болон мэдээлээгүй зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлант онд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,101,059.8 мянган төгрөгийн 4 орлогын гүйлгээ, 912,371.0 мянган төгрөгийн 11 зарлагын гүйлгээг мэдээлээгүй, 7 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д *”Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”,* 4.1.3-т *"тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”*, 6.4.5-д *“цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”* гэж заасантай тус тус нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хугацаанд нь иж бүрэн байршуулаагүй, зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

*Илрүүлэлт:* Мал эмнэлгийн салбарын 2025-2028 онд баримтлах стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлыг хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/14 дүгээр тушаалаар байгуулсан болович стратеги төлөвлөгөөг батлуулаагүй байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1-д *"Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна"* гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Мал эмнэлгийн салбарын стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулах.

*Илрүүлэлт:* Урьдчилан сэргийлэх зорилгоор хийгдэх төлөвлөгөөт дархлаажуулалтын нэгдсэн төлөвлөгөөг гаргаж хэвшээгүй, өвчин тус бүрээр төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Энэ нь Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т *"Эрсдэл ихтэй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараа онд хийгдэх төлөвлөгөөт дархлаажуулалтын нэгдсэн төлөвлөгөөг жил бүрийн хоёрдугаар улиралд багтаан энэ хуулийн 28.9-д заасан зөвлөлөөр хэлэлцүүлж, мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална"* гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Урьдчилан сэргийлэх зорилгоор хийгдэх төлөвлөгөөт дархлаажуулалтын нэгдсэн төлөвлөгөөг гаргаж хэвших.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар Мал эмнэлгийн ерөнхий газрын 2025 оны 3 дугаар улирлын байдлаарх санхүүгийн тайланг хамруулж, горим сорил хэрэгжүүлсэн.

Аудитын 546,473.2 мянган төгрөгийн илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа.

#### 4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 178,901.3 мянган төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгуулах 1 албан шаардлага, 1,735,825.6 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснийг нотлох баримтад үндэслэн хянаж үнэлэхэд 25.0 хувийн биелэлттэй байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 1 | 178,901.3 | 1 | 178,901.3 | 100.0 |
| Зөвлөмж | 3 | 1,735,825.6 | - | - | - |
| **Нийт дүн** | **4** | **1,914,726.9** | 1 | 178,901.3 | 25.0 |

Өмнөх оны аудитаар өгсөн төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүйгээс Шүүхийн шийдвэрийн дагуу байгууллагын төсвөөс олгосон нөхөн төлбөрийг хууль бус шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлж, төрийг хохиролгүй болгох 34,663.4 мянган төгрөгийн зөвлөмж, батлагдсан төсөв, зарцуулах эрхийн дагуу тохирох эдийн засгийн ангиллаас худалдан авалт хийх 32,880.0 мянган төгрөгийн зөвлөмж, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах 1,668,282.3 мянган төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар дараах асуудлыг анхаарах шаардлагатай гэж үзсэн. Үүнд:

- Мал эмнэлгийн системээр дамжуулан олгож буй 40 нэр төрлийн гэрчилгээний төлбөрийг системийн хөгжүүлэлт хийсэн компанийн дансанд төвлөрүүлсэн орлогыг тооцоо нийлсэн эсэх;
- Захиргааны хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүй халагдсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон 4 иргэнд ажилгүй байсан хугацааны цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 44,519.6 мянган төгрөгийг байгууллагын төсвөөс төлснийг гэм буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ авсан эсэх;
- Бараа материалын дансанд оны эцэст шаардлагагүй вакцин нөөцөлсөн эсэхийг дахин нягтлах шаардлагатай гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 10,540.0 мянган төгрөгийн 2 алдаа[1] илэрснийг аудитын явцад залруулсан.

*Залруулсан алдаа:*

- Тус газар автомашины гражийн түрээсийн гэрээг 2025-2026 оны хооронд 5-8 сараар хийсэн боловч урьдчилж гарсан зардлаар тайлагнаагүй, 2026 оны 10,240.0 мянган төгрөгийг шууд зардлаар хүлээн зөвшөөрч, тайлагнасан нь "УСНББОУС 1" Санхүүгийн тайлангийн толилуулга, Тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангаагүй;
- Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны А/265 тоот тушаалаар 2 албан хаагчийн төрийн дээд одон медалиар шагнагдсанд байгууллагаас тус бүр 150.0 мянган төгрөгийн дурсгалын бэлэг олгохоор заасан ч тус 2 албан хаагчид олгоогүйг балансад өглөгөөр тусгаагүй буруу илэрхийлсэн нь "УСНББОУС 1" Санхүүгийн тайлангийн толилуулга, Иж бүрэн байх, Үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүйг тус тус залруулсан.

Аудитаар нийт 3,819,486.4 мянган төгрөгийн 19 зөрчил[2] илэрснээс, 3,180.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 3,797,023.8 мянган төгрөгийн 12 албан шаардлага хүргүүлж, 19,282.6 мянган төгрөгийн 6 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 3,830,140.4 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 3,241,273.7 мянган төгрөгөөр давсан тул **“Хязгаарлалттай”** дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

***1. Зардалтай холбоотой асуудал***

Илрүүлэлт: Тайлант онд Нийслэлийн мал эмнэлгийн газрын Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчид 300.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг илүү тооцож олгосон. Мөн төсвийн жил дуусах хугацаанд Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын А/370, А/371, А/372 тоот тушаалаар 2,880.0 мянган төгрөгийн дотоод томилолтын зардлыг тушаал тус бүрээр нэг албан хаагчийн хувийн данс руу бөөн дүнгээр шилжүүлсэн зардлын зарцуулалт тодорхойгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах",* 16 дугаар зүйлийн 16.5.5-д *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах",* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно",* 13.7-д *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон, анхан шатны баримтаар нотлогдохгүй томилолтын зардлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 5.2 Албан шаардлага

***1. Орлоготой холбоотой асуудал***

*Илрүүлэлт:* Мал эмнэлгийн системээр дамжуулан олгож буй 40 нэр төрлийн гэрчилгээний төлбөрийг QR код ашиглан төлөхөд тус системийн хөгжүүлэлтийг хийсэн "Дижитал медик" ХХК-ийн дансанд төвлөрдөг ба тус компанитай орлогын тооцоог нийлдэггүй, орлогын гүйлгээнд тавих хяналт хангалтгүй тул орлогыг тулган баталгаажуулах боломжгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т *"Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"*, 6 дугаар зүйлийн 6.2.2-т *"Жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн батлаж, хэрэгжүүлэх"*, 41 дүгээр зүйлийн 41.1-д *"Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д *"дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Гэрчилгээний төлбөрийн орлогыг Мал эмнэлгийн ерөнхий газрын дансанд шууд төвлөрүүлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

***2. Зардалтай холбоотой асуудал***

*Илрүүлэлт:* Тайлант онд нийт 55,973.7 мянган төгрөгийн шатахуун болон талоныг 3 хуулийн этгээдээс 2023 оны гэрээг үндэслэн гэрээний сунгалт хийлгүй худалдан авсан, мөн хугацаа нь дууссан гэрээгээр оффисын түрээсийн зардлыг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д *"Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтал"*, 5.1.4-т *"үнэн зөв байх"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Гэрээний хугацаа дууссан, хүчин төгөлдөр бус гэрээг үндэслэн санхүүжилт олгосон зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

***3. Зардалтай холбоотой асуудал***

*Илрүүлэлт:* Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын тушаалаар Биокомбинат ТӨХХК-тай 2024 оны 12 дугаар сарын 27-нд "Тусгай зориулалт бүхий хөргүүрт 2023, 2024 онд авсан гоц халдварт өвчнөөс сэргийлэх вакцин хадгалах гэрээ"-г 195,600.0 мянган төгрөгөөр байгуулан Урьдчилж төлсөн зардлаар бүртгэсэн. Тус гэрээний хүчинтэй хугацаа 1 жил боловч хавсралтаарх зардлын задаргааг 2 жилээр тооцсон, түрээсийн хөргүүрийн хэмжээ болон $м^2$-д тооцох үнийн дүн тодорхойгүй, гэрээг албажуулсан тушаалын үндэслэл оновчгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.5-д *"зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, шийдвэр нь үндэслэл бүхий байх"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Тусгай зориулалт бүхий хөргүүрийг ашиглах түрээсийн гэрээнд хөргүүрийн хэмжээ болон м2-д тооцох үнийн дүн тодорхойгүй гэрээ байгуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

***4. Зардалтай холбоотой асуудал***

*<u>Илрүүлэлт:</u>* Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлаас дотоод томилолтын зардалд 19,174.3 мянган төгрөг, гадаад томилолтын зардалд 206,428.7 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 41,427.4 мянган төгрөг, нийт 267,030.3 мянган төгрөгийг зарцуулж, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах",* 41 дүгээр зүйлийн 41.2.3-т *"төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах",* 42.3.1-д *"төсвийн захирагч нь төсөвт зохицуулалт хийх саналаа харьяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагчид, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаггүй бол төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх",* "Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан *"Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь:</u>* Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зардлын эдийн засгийн ангиллыг зориулалтын дагуу зарцуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

***5. Зардалтай холбоотой асуудал***

*<u>Илрүүлэлт:</u>* Тайлант онд томилолтын зардалтай холбоотой нийт 257,436.9 мянган төгрөгийн дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

1. Гадаад, дотоод томилолтын 130,907.7 мянган төгрөгийг нэг албан хаагчийн хувийн данс руу бөөн дүнгээр шилжүүлсэн;
2. Мал эмнэлгийн ерөнхий газрын харьяа орон нутгийн мал эмнэлгийн газрын дарга, албан хаагч болон Нийслэлийн мал эмнэлгийн газрын байцаагчид болох нийт 16 хүнд 106,627.1 мянган төгрөгийн албан томилолт олгосон;
3. Тайлант хугацаанд 19,902.1 мянган төгрөгийн Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын А/289, А/307 тоот тушаалуудаар гадаад томилолтоор ажиллахдаа үндэсний агаарын тээвэрлэгч компанийг сонгоогүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах",* 16 дугаар зүйлийн 16.5.5-д *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах",* Монгол Улсын Ерөнхий Сайдын 2025 оны 05 дугаар "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" албан даалгаврын 1.4-т *"тэвчиж болох дараах арга хэмжээ, зардлын санхүүжилтийг 2025 он дуустал хугацаанд зогсоож, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг хэмнэлттэй, үр ашигтай байдлаар зохион байгуулах",* 1.4.1-д *"хурал, семинар, сургалтыг цахимаар зохион байгуулж, дотоод, гадаад томилолт, тээвэр шатахуун, зочин, төлөөлөгч хүлээн авах зардлыг хэмнэх",* Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т *"Энэ хуулийн 3.1-д заасан этгээд нэн тэргүүнд үндэсний агаарын тээвэрлэгчийг сонгож үйлчлүүлнэ"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь:</u>* Гадаад, дотоодын томилолтын зардлыг нэг албан хаагчийн хувийн данс руу бөөн дүнгээр шилжүүлсэн, харьяа байгууллагын албан тушаалтнуудад томилолтын зардал олгосон, үндэсний агаарын тээвэрлэгч компанийг сонгоогүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

***6. Авлагатай холбоотой асуудал***

*<u>Илрүүлэлт:</u>* Захиргааны хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүй халагдсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон 4 иргэнд ажилгүй байсан хугацааны цалин,

ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 44,519.6 мянган төгрөгийг байгууллагын төсвөөс төлснийг гэм буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ аваагүй, санхүүгийн тайланд авлага үүсгэсэн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д *"Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ",* 103.2-т *“Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна”* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Өмнөх аудитаар өгсөн шүүхийн шийдвэрийн дагуу байгууллагын төсвөөс олгосон нөхөн төлбөрийг хууль бус шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлж, төрийг хохиролгүй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

***7. Авлагатай холбоотой асуудал***

*Илрүүлэлт:* Төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд цалингийн болон Нийгмийн даатгалын шимтгэлийн 1,187.9 мянган төгрөгийн авлага, Хувь хүний орлогын албан татварын 105.8 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д *"төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх",* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д *"дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Төсвийг зохистой удирдаагүйгээс жилийн эцсийн тайлангаар авлага, өглөг үүсгэсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

***8. Бараа материалтай холбоотой асуудал***

*Илрүүлэлт:* Бараа материалын дансанд оны эцэст шаардлагагүй вакцин нөөцөлснөөс үүдэн 2017-2025 онд хугацаа нь дууссан цаашид ашиглах боломжгүй нийт 349,313.9 мянган төгрөгийн 6 нэр төрлийн вакцин, 2 нэр төрлийн шингэлэгчийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т *"батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих",* 16.5.4-т *"төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Бараа материалын дансанд үлдэгдэлтэй хугацаа дууссан вакцин нөөцөлсөн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

***9. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал***

*Илрүүлэлт:* Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны А/50 дугаар тушаалаар газрын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлахдаа нийт 226,000.0 мянган төгрөгийн нэг төрлийн ажил үйлчилгээг гэрээ шууд байгуулах аргыг ашиглахаар олон салгаж худалдан авахаар төлөвлөсөн, тус тушаалын хэрэгжилт, үр дүнг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т *“санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”*, 6 дугаар зүйлийн 6.4.1-д *“төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т *"Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно"*, 10.5-д *"Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно"*, 44 дүгээр зүйлийн 44.1-д *"Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална"*, 46 дугаар зүйлийн 46.1-д *"Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана"*, 46.2-т *“Төсвийн ерөнхийлөн захирагч харьяа захиалагчийн худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн дараа оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахим системээр тайлагнана"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хуульд нийцүүлэн төлөвлөөгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

***10. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал***

*Илрүүлэлт:* Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/51-А/59 дүгээр, А/105, А/106 дугаар тушаалуудаар Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагаа болон малын эмийн зохистой хэрэглээ, хүртээмж, хангамжийг олон нийтэд мэдээлэн сурталчлан таниулах арга хэмжээний төсөвт өртгийг хуваан 11 хэвлэл мэдээллийн байгууллагатай шууд гэрээ байгуулж, гүйцэтгэлээр нийт 148,920.0 мянган төгрөгөөр ажил гүйцэтгүүлэх гэрээг байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т *"Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно"*, 10.5-д *"Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Төсөвт өртгийг хуваах, худалдан авах ажиллагаа зохион байгуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

***11. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал***

*Илрүүлэлт:* Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй нийт 229,504.8 мянган төгрөгийн ажил гүйцэтгэх, вакцин, шингэлэгч худалдан авах гэрээг байгуулсан байна.

1. Орон нутагт вакцин тээвэрлүүлэх ажил гүйцэтгэх гэрээг 3 Аж ахуйн нэгж, 1 иргэнтэй нийт 78,304.8 мянган төгрөгийн гэрээг байгуулан санхүүжилт олгосон;
2. “Гоц халдварт хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин, шингэлэгч”-ийг Нэг эх үүсвэрээс худалдан авах аргыг ашиглан Биокомбинат ТӨХХК-тай 151,200.0 мянган төгрөгийн гэрээг 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т *"Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно"*, 10.5-д *"Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй шууд худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Зардалтай холбоотой асуудал***

*Илрүүлэлт:* Мал эмнэлгийн ерөнхий газар нь 2022 оноос хойш бүтэцтэй холбоотой тушаал гараагүй бөгөөд Чиг үүргийн шинжилгээ хийлгэж ажлын байрны ачааллыг жигдрүүлэх талаар Төрийн албаны зөвлөлөөс өгсөн чиглэлийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.9-д *"Дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох"* гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Төрийн албаны зөвлөлөөс өгсөн чиглэлийг хэрэгжүүлэн, чиг үүргийн шинжилгээг хийж холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

***2. Бараа материалтай холбоотой асуудал***

*Илрүүлэлт:* Бараа материалын дансанд бүртгэлтэй Мал эмнэлгийн системээр дамжуулан олгож буй 40 нэр төрлийн гэрчилгээг холбогдох албан тушаалтнуудтай хоорондын тооцоо нийлж баталгаажуулаагүй, Мал эмнэлгийн хяналт, баталгаажуулалтын газрын гэрчилгээ хариуцсан албан хаагчдад их хэмжээний үлдэгдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т *"үнэн зөв байх"*, 13 дугаар зүйлийн 13.1-д *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно"*, 20 дугаар зүйлийн 20.2.6-д *"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"*, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1-д *"өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах"*, 70 дугаар зүйлийн 70.2 дахь хэсгийн 2-т *“Түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/”* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Бараа материалын дансанд бүртгэлтэй Мал эмнэлгийн системээр дамжуулан олгож буй гэрчилгээг холбогдох албан тушаалтнуудтай хоорондын тооцоо нийлж баталгаажуулах.

***3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал***

*<u>Илрүүлэлт</u>:* Программ хангамжийн дансанд нийт 19,282.6 мянган төгрөгийн мэдээлэл технологийн материалуудыг ангилал зөрүүлэн орлогодсон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т *"үнэн зөв байх",* 20 дугаар зүйлийн 20.2.4-т *"нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах",* Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1-д *"өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах",* ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан журмын 4.6-д *"Үндсэн хөрөнгийн дансанд Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын "хүлээн зөвшөөрөлтийн зарчим" хангагдсан, үндсэн хөрөнгийн шинжийг хадгалсан хөрөнгийг бүртгэнэ"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>* Үндсэн хөрөнгийн дансанд хөрөнгийн шинж чанартай хөрөнгүүдийг ангиллын дагуу бүртгэх.

***4. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал***

*<u>Илрүүлэлт</u>:* Мал эмнэлгийн ерөнхий газар нь ТӨБЗГ-ын 2025 оны "Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай" 45 дугаар тогтоолоор 7 нэр төрлийн 8,598.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, программ хангамжийг үндсэн хөрөнгийн данснаас хассан ч, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад зохион байгуулж баримтжуулж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах",* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т *"үнэн зөв байх",* 20 дугаар зүйлийн 20.2.4-т *"нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах",* Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1-д *"өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>* Үндсэн хөрөнгийн данснаас хасаж устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт хэрэгжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тус газар автомашины гражийн түрээсийн гэрээг 2025-2026 оны хооронд 5-8 сараар хийсэн боловч урьдчилж гарсан зардлаар тайлагнаагүй 2026 оны 10,240.0 мянган төгрөгийг шууд зардлаар хүлээн зөвшөөрч, тайлагнасан байна. | 1 | 10,240.0 | | | 1 | 10,240.0 | 1 | 10,240.0 | | | | |
| МЭЕГ-ын даргын 2025 оны А/265 тоот тушаалаар 2 албан хаагчийн төрийн дээд одон медалиар шагнагдсанд байгууллагаас тус бүр 150.0 мянган төгрөгийн дурсгалын бэлэг олгохоор заасан ч тус 2 албан хаагчид олгоогүйг балансад өглөгөөр тусгаагүй байна. | 1 | 300.0 | | | 1 | 300.0 | 1 | 300.0 | | | | |
| **Дүн** | **2** | **10,540.0** | | | **2** | **10,540.0** | **2** | **10,540.0** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: Төлбөрийн акт | | Үүнээс: Албан шаардлага | | Үүнээс: Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Мал эмнэлгийн салбарын 2025-2028 онд баримтлах стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлыг хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/14 тоот тушаалаар байгуулсан болович стратеги төлөвлөгөөг батлуулаагүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Мал эмнэлгийн ерөнхий газар нь 2022 оноос хойш бүтэцтэй холбоотой тушаал гараагүй бөгөөд Чиг үүргийн шинжилгээ хийлгэж ажлын байрны ачааллыг жигдрүүлэх талаар Төрийн албаны зөвлөлөөс өгсөн чиглэлийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Урьдчилан сэргийлэх зорилгоор хийгдэх төлөвлөгөөт дархлаажуулалтын нэгдсэн төлөвлөгөөг гаргаж хэвшээгүй, өвчин тус бүрээр төлөвлөгөө гаргаж ажиллаж байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Мал эмнэлгийн системээр дамжуулан олгож буй 40 нэр төрлийн гэрчилгээний төлбөрийг QR код ашиглан төлөхөд тус системийн хөгжүүлэлтийг хийсэн "Дижитал медик" ХХК-ийн дансанд төвлөрдөг ба тус компанитай орлогын тооцоог нийлдэггүй, орлогын гүйлгээнд тавих хяналт хангалтгүй тул орлогыг | 1 | - | | | 1 | - | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| тулган баталгаажуулах боломжгүй байна. | | | | | | | | | | | | |
| Тайлант онд нийт 55,973.7 мянган төгрөгийн шатахуун болон талоныг 3 хуулийн этгээдээс 2023 оны гэрээг үндэслэн гэрээний сунгалт хийлгүй худалдан авсан, мөн хугацаа нь дууссан гэрээгээр оффисын түрээсийн зардлыг олгосон байна. | 1 | 55,973.7 | | | 1 | 55,973.7 | | | | | | |
| Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын тушаалаар Биокомбинат ТӨХХК-тай 2024 оны 12-р сарын 27-нд "Тусгай зориулалт бүхий хөргүүрт 2023, 2024 онд авсан гоц халдварт өвчнөөс сэргийлэх вакцин хадгалах гэрээ"-г 195,600.0 мянган төгрөгөөр байгуулан Урьдчилж төлсөн зардлаар бүртгэсэн. Тус гэрээний хүчинтэй хугацаа 1 жил боловч хавсралтаарх зардлын задаргааг 2 жилээр тооцсон, түрээсийн хөргүүрийн хэмжээ болон м2-д тооцох үнийн дүн тодорхойгүй, гэрээ байгуулах тушаалын эрх зүйн үндэслэл оновчтой биш байна. | 1 | 195,600.0 | | | 1 | 195,600.0 | | | | | | |
| Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлаас дотоод томилолтын зардалд 19,174.3 мянган төгрөг, гадаад томилолтын зардалд 206,428.7 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 41,427.4 мянган төгрөг, нийт 267,030.3 мянган төгрөгийг зарцуулж, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. | 1 | 267,030.3 | | | 1 | 267,030.3 | | | | | | |
| Тайлант онд томилолтын зардалтай холбоотой нийт 257,436.9 мянган төгрөгийн дараах зөрчлүүд илэрсэн. | 1 | 257,436.9 | | | 1 | 257,436.9 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үүнд: 1. Гадаад, дотоод томилолтын 130,907.7 мянган төгрөгийг нэг албан хаагчийн хувийн данс руу бөөн дүнгээр шилжүүлсэн;<br>2. Мал эмнэлгийн ерөнхий газрын харьяа орон нутгийн мал эмнэлгийн газрын дарга, албан хаагч болон Нийслэлийн мал эмнэлгийн газрын байцаагчид болох нийт 16 хүнд 106,627.1 мянган төгрөгийн албан томилолт олгосон;<br>3. Тайлант хугацаанд 19,902.1 мянган төгрөгийн Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын А/289, А/307 тоот тушаалуудаар гадаад томилолтоор ажиллахдаа үндэсний агаарын тээвэрлэгч компанийг сонгоогүй байна. | | | | | | | | | | | | |
| Тайлант онд Нийслэлийн мал эмнэлгийн газрын Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчид 300.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг илүү тооцож олгосон. Мөн төсвийн жил дуусах хугацаанд МЭЕГ-ын даргын А/370, А/371, А/372 тоот тушаалаар 2,880.0 мянган төгрөгийн дотоод томилолтын зардлыг тушаал тус бүрээр нэг албан хаагчийн данс руу бөөн дүнгээр шилжүүлсэн зардлын зарцуулалт тодорхойгүй байна. | 1 | 3,180.0 | 1 | 3,180.0 | | | | | | | | |
| Захиргааны хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүй халагдсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон 4 иргэнд ажилгүй байсан хугацааны цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 44,519.6 мянган төгрөгийг байгууллагын төсвөөс төлснийг гэм буруутай албан | 1 | 44,519.6 | | | 1 | 44,519.6 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ аваагүй, санхүүгийн тайланд авлага үүсгэсэн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. | | | | | | | | | | | | |
| Төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд цалингийн болон НДШ-ийн 1,187.9 мянган төгрөгийн авлага, ХХОАТ-ын 105.8 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна. | 1 | 1,293.8 | | | 1 | 1,293.8 | | | | | | |
| Бараа материалын дансанд оны эцэст шаардлагагүй вакцин нөөцөлснөөс үүдэн 2017-2025 онд хугацаа нь дууссан нийт 349,313.9 мянган төгрөгийн 6 нэр төрлийн вакцин, 2 нэр төрлийн шингэлэгчийг цаашид ашиглах боломжгүй агуулахад хадгалагдаж байна. | 1 | 349,313.9 | | | 1 | 349,313.9 | | | | | | |
| Бараа материалын дансанд бүртгэлтэй Мал эмнэлгийн системээр дамжуулан олгож буй 40 нэр төрлийн гэрчилгээг холбогдох албан тушаалтнуудтай хоорондын тооцоо нийлж баталгаажуулаагүй, Мал эмнэлгийн хяналт, баталгаажуулалтын газрын гэрчилгээ хариуцсан албан хаагчдад 40 нэр төрлийн гэрчилгээ их хэмжээний үлдэгдэлтэй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Программ хангамжийн дансанд нийт 19,282.6 мянган төгрөгийн мэдээлэл технологийн материалуудыг ангилал зөрүүлэн орлогодсон байна. | 1 | 19,282.6 | | | | | 1 | 19,282.6 | | | | |
| МЭЕГ нь ТӨБЗГ-ын 2025 оны "Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай" 45 дугаар тогтоолоор 7 нэр төрлийн 8,598.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, | 1 | - | | | | | 1 | - | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| программ хангамжийг үндсэн хөрөнгийн данснаас хассан ч, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад зохион байгуулж баримтжуулж ажиллаагүй байна. | | | | | | | | | | | | |
| Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны А/50 дугаар тушаалаар газрын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлахдаа нийт 226,000.0 мянган төгрөгийн нэг төрлийн ажил гүйлгээг гэрээ шууд байгуулах аргыг ашиглахаар олон салгаж худалдан авахаар төлөвлөсөн, тус тушаалын хэрэгжилт, үр дүнг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлээгүй байна. | 1 | 226,000.0 | | | 1 | 226,000.0 | | | | | | |
